

**Ж.ПИТЕР МОРРОУГИЙН НЭРЭМЖИТ
ХААН БАНКНЫ ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ**

2023 оны 4-р сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Зорилго:

Монгол улсад банк, санхүүгийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн оюутнуудын мэдлэг, ур чадварыг хөгжүүлж, ирээдүйн чадварлаг боловсон хүчнийг нээн илрүүлэх зорилготой.

Оролцогчид:

Оролцогчид нь Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургуулийн оюутан (*ганцаарчилсан болон багийн төрөлд*) байна. Улаанбаатар хотын хувьд, нэг сургуулиас **2-оос** дээшгүй баг оролцох боломжтой. Орон нутаг дахь салбар сургуулийн хувьд, тусдаа баг бүрдүүлж оролцох боломжтой.

Багт тавигдах шаардлага:

- Баг тус бүр 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.
- Багийн гишүүд тухайн сургуулийнхаа 3, 4-р дамжааны оюутан байна.
- Ганцаарчилсан төрөлд зөвхөн багийн гишүүд оролцоно. (*Багт ороогүй оюутан ганцаарчилсан төрөлд оролцох боломжгүй.*)

Олимпиадын хөтөлбөр:

№	Хөтөлбөр	Огноо	Цаг	Хаана
1	Бүртгэл	2023.05.01 хүртгэл		И-мэйлээр бүртгүүлнэ.
2	Техникийн зөвлөгөөн	2023.05.02	16:00	Microsoft Teams програмаар явагдана.
3	Тестийн шалгалт, НББ-н нэгдсэн бодлого (Хувийн төрөл)	2023.05.09	10:00-12:00	ХААН Банк цамхаг*
4	Кейс ажиллавар - 1, 2 (Багийн төрөл)	2023.05.12	10:00-13:00	
5	Тэргүүлэгч 5 баг шүүгчдэд кейс ажиллавар танилцуулах	2023.05.12	15:00-17:00	
6	Олимпиадын дүнг танилцуулах	2023.05.12	17:00	

* Чингисийн өргөн чөлөө-6, Стадион-1, “Наадам центр”-ийн хажууд, Хан-Уул дүүрэг

Тайлбар:

- Кейс хамгаалах: Хоёр кейс ажиллаврын нийлбэр дүнгээр өндөр оноотой 5 баг 10 минутад багтаан танилцуулга хийж 10 минутад асуултад хариулна. Танилцуулга хийх дарааллыг сугалаагаар шийдвэрлэнэ.
- Техникийн зөвлөгөөний үеэр олимпиадын хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.

Тест шалгалтын сэдвүүд:

- Банкны менежмент
- Зээлийн шинжилгээ
- Өгөгдлийн шинжилгээ
- Мэргэжлийн англи хэл
- Банкны нягтлан бодох бүртгэл
- Эрсдэлийн менежмент
- Банкны тухай хууль, журам
- Бусад

Шалгалтын материалыг олимпиадыг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүд боловсруулна.

Багуудыг дүгнэх:

- Кейс ажиллагаа 60%
- Илтгэл 15%
- Кейс хамгаалалт 25%

Шагнал урамшуулал:

Багийн төрөлд:

I байр - Цом, өргөмжлөл, 2,000,000 төгрөг

II байр - Цом, өргөмжлөл, 1,500,000 төгрөг

Ганцаарчилсан төрөлд:

I байр - Өргөмжлөл, мөнгөн шагнал

II байр - Өргөмжлөл, мөнгөн шагнал

III байр - Өргөмжлөл, мөнгөн шагнал

Эхний 5 байрт шалгарсан оюутнуудад **ХААН Банканд ажилд орох урилга** (Хэрэв 3-р дамжааны оюутан бол ажилд орох урилга нэг жилийн хугацаанд хадгалагдана).

Жич: Ганцаарчилсан төрөлд оролцогчдын оноо тэнцсэн тохиолдолд байр эзлүүлэх шалгуур нь НББ-н нэгдсэн бодлогоор авсан оноо байна.

Багийн болон хувийн дүнгээр тэргүүлсэн сургууль Шилжин явах цомын эзэн болно.

Бүртгэл :

Олимпиадад оролцох оюутнуудын бүрдүүлэх материал:

- Иргэний үнэмлэх
- Оюутны үнэмлэх
- Багийн бүх гишүүнийг багтаасан сургуулийн тодорхойлолт

*Олимпиадад оролцох багууд бүрдүүлэх материалыг сканердаж Tsetsegdelger.e@khanbank.com хаяг руу ирүүлнэ. Бүртгэл ирүүлсэн и-мэйл хаяг руу техникийн зөвлөгөөний хурлын холбоосыг хүргүүлнэ.

Анхаарах зүйлс:

- Материал дутуу ирүүлсэн баг болон оюутныг бүртгэхгүй.
- Олимпиадад хүрэлцэн ирэхдээ цахим үнэмлэх болон оюутны үнэмлэхээ заавал авч ирнэ.
- Бичиг баримтгүй ирсэн тохиолдолд олимпиадад оролцох боломжгүй.

Бусад: Олимпиадын зааварчилгаа болон бусад асуудлуудыг техникийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Холбоо барих:

Б.Бөхбаатар: 75153333 (5985), 8024-6755
Б.Батсүх: 75153333 (3335), 9901-9786

ХАМТДАА МЭДЛЭГЭЭ ӨСГӨЕ